

“УЛААНБААТАР ХОТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ ХАНГАХ 3R (REDUCE, REUSE, RECYCLE) ДАДАЛ БУЮУ 3R4UB” ТӨСЛИЙН ВЭБСАЙТ ХИЙХ, ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

| | |
|-----------------------|--|
| Төслийн нэр: | “Улаанбаатар хотын байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээг хангах 3R (reduce, reuse, recycle) дадал буюу 3R4UB” төсөл |
| Лавлах дугаар: | 5.8.3 |
| Хугацаа: | 2022 оны 10-р сарын 14 - 2022 оны 11-р сарын 30 |
| Төсөв: | 9,634,860 төгрөг |

НЭГ. Ерөнхий зүйл

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв нь SWITCH-Asia ба Төв Ази II буюу Тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэлийг дэмжих нь хөтөлбөрийн хүрээнд Европын холбооноос санхүүжүүлж буй “Улаанбаатар хотод 3R зарчмыг хэрэгжүүлэх замаар байгалийн нөөцийг тогтвортой ашиглах (3R4UB)” төслийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Итали Улсын Үндэсний судалгааны зөвлөл, Итали Улсын хог хаягдлын менежментийг хэрэгжүүлдэг “Металлиа сервизи” компани хамтран хэрэгжүүлж байна.

Монгол улсын хэмжээнд бүх нийтийг оролцуулсан тогтвортой хөгжлийг бий болгох, ядуурлыг бууруулах, ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулан нүүрстөрөгч бага ялгаруулдаг, байгалийн нөөцийг үр ашигтай ашигладаг эдийн засгийг дэмжих үндсэн зорилготой төсөл юм.

ХОЁР. Ажлын зорилго

3R4UB төсөл (<https://3r4ub.org/>)-ийн англи хэл дээрх үндсэн болон дэд цахим хуудасны загварыг сайжруулж төслийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сурталчлан таниулахад мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, ашиглахад хялбар, мэдээ мэдээллийг түргэн шуурхай авах боломжтой, гар утас болон суурин компьютероос ачаалах боломжтой цахим хуудасны монгол хэлний сонголттой хувилбарыг хөгжүүлэх

ГУРАВ. Бүтээгдэхүүн үйлчилгээ болон гүйцэтгэгчид тавигдах шаардлага

3.1 Тавигдах ерөнхий шаардлага

| № | Тавигдах шаардлага | Нэмэлт тайлбар |
|---|--|---|
| 1 | Үндсэн вэбсайтын загвар (WealthCo) | |
| 2 | Вэб сайтын хамгаалалт болон аюулгүй байдлыг хангасан байх | |
| 3 | Сайт нь динамик; | |
| 4 | Вэб удирдлагын системтэй байх | CMS |
| 5 | Удирдлагын вэбсайт бүрэн HTTPS холболт дээр ажилладаг байх | |
| 6 | Вэб хариуцсан мэргэжилтэнд заавар зөвлөгөө өгч хүлээлгэн өгнө. | Үүнд: тухайн вэбсайтын код /template/, мэдээллийн баазын нууц үг, админ эрхийн нууц үг гэх мэт. |

| | | |
|----|---|--|
| 7 | Mobile responsive | Бүх төрлийн гар утас болон таблет дээр хэвийн ажилладаг байх. |
| 8 | Google SEO | Хайлтын системийн тохиргоо хийгдсэн байх, мөн google analytic ашигласан байх |
| 9 | Banner management | Баннерыг удирдах боломжтой байх. |
| 10 | Content management | Зураг, текст, видео контент оруулах өөрчлөх боломжтой байх |
| 11 | Search module /related & tagged / | Хайлтын модуль: ижил төстэй утгаар, түлхүүр үгээр. Хандалт хийхэд хурдан дуудагддаг байх шийдлийг сонгосон байх; |
| 12 | Вэбсайтыг компьютерээс гадна жижиг дэлгэцтэй төхөөрөмжүүд болох таблет, мобайл төхөөрөмжид харуулах зорилгоор хүрээ хэрэглэлгүй CSS хэрэглэсэн байх хэрэгтэй. | |
| 13 | Мэдээ мэдээллүүдийг оруулахдаа pdf, jpeg, видео форматаар оруулах боломжтой байх | |
| 14 | Вебсайт 2 жилийн баталгаат хугацаатай байна | Баталгаат хугацаанд шаардлагатай засвар үйлчилгээ, нэмэлт өөрчлөлтийг хийж өгнө. |

3.2. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага

Ажил гүйцэтгэгч нь мэргэшил, ур чадварын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- PHP, MySql программын хэлний зохих ёсны мэдлэгтэй ажилтантай байх;
- Агуулах удирдах систем(CMS) дээр хөгжүүлэлт хийж байсан туршлагатай байх
- Төслөөс өгсөн даалгаврын дагуу бие даан ажиллах чадвартай байх
- Томоохон хэмжээний цахим хуудас, портал сайт хийж гүйцэтгэхтэй холбоотой ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Гүйцэтгэх эцсийн хугацаа : 2022-11-30

ДӨРӨВ. Мэдээ, тайлан

- Захиалагч болон гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнд заасан хугацаагаар ажил эхэлж, гүйцэтгэлийн тайланг хүлээлгэн өгч ажил гүйцэтгэсэн акт гүйцэтгэж өгснөөр ажил дуусгавар болно.
- Ажил гүйцэтгэгч ажлын явц, гүйцэтгэлд Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн Судалгаа, мэдээлэл, сургалтын албаны дарга буюу ЗР4UB Төслийн менежер байнгын хяналт тавина.

- Ажил гүйцэтгэгч нь Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн 3R4UB Төслийн багийн холбогдох ажилтнуудтай байнгын холбоотой ажиллана.

ТАВ. Мэдээллийн нууцлал ба өмчлөл

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн зүгээс өгсөн мэдээ, мэдээллийг баталгаажсан албан бичиг зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Гүйцэтгэх ажлын хүрээнд боловсруулсан эх бэлтгэл, зурагт хуудас зэрэг нь захиалагч талын өмч байна.

ЗУРГАА. Санал ирүүлэх материал

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, танилцуулга
- Үнийн санал
- Өмнө хийж байсан бүтээлүүдийн жагсаалт
- Энэхүү ажлыг хийж гүйцэтгэх урьдчилсан санал, төлөвлөгөө
- Хүний нөөцийн чадавхийн мэдээлэл (CV, бусад нотлох баримт)
- Ижил төстэй ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагын мэдээлэл (Гэрээ, гэрээ дүгнэсэн акт)

Саналаа дараах хаягаар ирүүлнэ:

“Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв” УТҮГ
Хан-Уул дүүрэг 11-р хороо Зайсангийн гудамж -9
Утас: 70107644